



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 09 сарын 30 өдөр

Дугаар А/54


Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудлын зөвшөөрөл  
хүчингүй болгох тухай

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 7.7.4, нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3 дахь заалт, иргэн, аж ахуйн нэгжийн бичгээр гаргасан хүсэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Зочид буудал, дэн буудлын үйл ажиллагаа эрхлэгч нь өөрчлөгдсөн Баянгол дүүргийн 4 дүгээр хороонд байрлах "Агид Бэл" ХХК-ын "Их Улс" зочид буудлын 13/120 тоот, Баянзүрх дүүргийн 15 дугаар хороонд байрлах "Ихэр зул" ХХК-ын "Лассо" дэн буудлын 13/21 тоот, иргэн С.Гантөмөрийн "Сан мүүн" дэн буудлын 14/002 тоот зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2. Энэхүү тушаалыг холбогдох байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг мэргэжилтэн /С.Туул/-д даалгасугай.

ДАРГА  Э.БАТТУЛГА

